

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа /цаашид “аюултай ачаа” гэх/ аюулгүй тээвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, хяналт тавихад оршино.
- 1.2. Энэхүү журмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт усан замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалахад оролцогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөнө.
- 1.3. Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэлтийг усан замын тээврийн хэрэгслийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэд /цаашид “тээвэрлэгч” гэх/ гүйцэтгэнэ.
- 1.4. Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэлтийг 2017 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын “Усан замын тээврийн тухай” хуулийн дагуу гүйцэтгэнэ.

ХОЁР. АЮУЛТАЙ АЧААНЫ АНГИЛАЛ БА ТҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. “Аюултай ачаа” гэж усан замаар тээвэрлэх үед тэсрэх, гал авалцах, байшин барилга, тоног төхөөрөмж, агуулах сав, тээврийн хэрэгслийг эвдэх, хүн мал, амьтныг гэмтээх, хордуулах, түлэх, хорт туяаны цацрагаар шарах, өвчлүүлэх зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулах бодис, биет материал бүхий ачааг;
- 2.2. “Ачааны оноосон нэр” гэж тээврийн баримт бичиг, ачааны мэдэгдэл, баглаа боодолд тухайн бодис болон эд зүйлийг аюултай ачааны техникийн зааварчилгад дурьдсаны дагуу тодорхойлон бичсэнийг;
- 2.3. “Баглаа боодол” гэж аюултай ачааны техникийн зааварчилгад тусгагдсан шаардлагыг хангасан хайрцаг сав болон түүний бүрэлдэхүүн хэсгийг;
- 2.4. “Гадуур баглаа боодол” гэж нэг буюу хэд хэдэн ачааг зөөх, хадгалах, тээвэрлэхэд тохиромжтой байхаар нэг нэгж болгох боож баглахыг;
- 2.5. “Ачиж буулгах төхөөрөмж” гэж зогсоол дээр буюу усан замын тээврийн хэрэгслийн тавцан дээр байрлах ачааг ачиж буулгахад зориулагдсан төхөөрөмжийг;
- 2.6. “Савлалт” гэж эд зүйлс болон бодисыг хайрцаг саванд хийж найдвартай, аюулгүй боож баглахыг;
- 2.7. “Аюултай ачааны техникийн нөхцөл” гэж аюултай ачааг усан замаар болон бусад тээврийн хэрэгслээр аюулгүй тээвэрлэхэд зориулан Олон улсын байгууллагаас баталсан хүчин төгөлдөр баримт бичгийг тус тус хэлнэ.
- 2.8. Аюултай ачааг дараах байдлаар ангилна. Үүнд:
 - 2.8.1. Тэсэрч дэлбэрэх бодисууд;
 - 2.8.2. Шахсан хий, даралтаар хадгалсан уусмалууд;

- 2.8.3. Амархан гал авалцах шингэнүүд;
- 2.8.4. Амархан гал авалцах бодис, биет материалууд;
- 2.8.5. Хүчиллэг бодисууд;
- 2.8.6. Хортой болон халдвар тараах бодисууд;
- 2.8.7. Цацраг идэвхит бодисууд;
- 2.8.8. Идэмхий болон зэврээх бодисууд;
- 2.8.9. Бусад хорт бодисууд.

2.9. Аюултай ачааны ангилал тус бүрийг аюултай ачааны техникийн нөхцөлд заасны дагуу бүлэглэнэ.

ГУРАВ. АЮУЛТАЙ АЧААНЫ ТЭЭВЭРЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Аюултай ачааг илгээх, тээвэрлэх:

3.1.1. Аюултай ачаа илгээгч нь “Химийн хорт болон бодисын тухай” хууль, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай” хууль, “Цөмийн энергийн тухай хууль”, “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актад заасан нөхцөл, шаардлагыг хангасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.

3.1.2. Аюултай ачаа тээвэрлэгч нь дараахь тохиолдолд тухайн аюултай ачааг тээвэрлэхээс татгалзана. Үүнд:

- Тухайн аюултай ачаа нь тээвэрлэх, ачиж буулгах, шилжүүлэн ачихад аюултай ачааны техникийн нөхцлийн дагуу зохион байгуулах боломжгүй;
- Тухайн аюултай ачааны техникийн нөхцөлд усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглосон зүйл заалт байвал;
- Аюултай ачааны холбогдох баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд.

3.1.3. Аюултай ачааны тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд оролцох аливаа этгээд нь усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдсан байна.

3.1.4. Аюултай ачаа илгээгч нь аюултай ачаа тээвэрлэхдээ нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан баримт бичгийг бүрдүүлж хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргаж зөвшөөрөл авсаны үндсэн дээр тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцоно.

3.1.5. Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэхдээ дараах баримт, бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аюултай ачаа тээвэрлэх, хадгалах болон ашиглах зөвшөөрөл;
- Тээвэрлэх ачааны оноосон нэр, тодорхойлолт, ачааны ГНГ /ачааны уялдуулсан нэрсийн жагсаалт/ код;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон авултай ачааны дугаар, ослын дугаар;
- Усан замын тээврийн хэрэгслийн төрөл, зориулалт;
- Аюултай ачааны нэгж жин, нийт жин;
- Аюултай ачааны сав, баглааны төрөл, стандарт, техникийн нөхцөл;
- Хүлээн авах ААНБ, иргэн, илгээх, хүрэх болон, дамжин өнгөрөх өртөөг заасан мэдээлэл;
- Илгээгч болон хүлээн авагчийн нэр, хаяг, холбогдох мэдээлэл;
- Лабораторын шинжилгээний дүн.

3.1.6. Аюултай ачаа илгээгч нь хүсэлтийн хамт аюултай ачаатай холбоотой баримт бичгийг ирүүлээгүй эсхүл дутуу бүрдүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллага зөвшөөрөл олгохгүй.

3.1.7. Аюултай ачаа илгээгч нь эрх бүхий этгээд, байгууллагаар баталгаажуулсан тээврийн баримт бичгийг хоёр хувь үйлдэж тээвэрлэгчид хүлээлгэн өгнө.

3.1.8. Аюултай ачааг тээвэрлэх хугацааг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу урьдчилан зөвшилцсөн байна.

3.1.9. Аюултай ачаа тээвэрлэгч нь анхан шатны тусламж, аливаа ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг мэдэж байхаас гадна хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас, эм, багажны иж бүрдэл, гал унтраах болон хорт хийн баг, бусад туслах материалыг байнгын авч явах ба тээвэрлэлтийн туршид аюулгүй ажиллагааны нөхцөл хангагдаж байгаа эсэхэд хяналт тавина.

3.1.10. Аюултай ачаа тээвэрлэх явцад осол, зөрчил гарсан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушааланд яаралтай мэдэгдэнэ.

3.1.11. Аюултай ачааг зориулалтын усан замын тээврийн хэрэгсэл эсхүл тусгай зориулалтаар тоногдсон ердийн усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Аюултай ачааны техникийн ашиглалтын шаардлага хангасан, үйлдвэрлэгчдээс тавьсан заавар, таних тэмдэг, тэмдэглэгээ шошго тавигдсан, холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт нь үнэ зөв эрх бүхий этгээд /байгууллага/-аар баталгаажуулагдсан, аюулгүйн зааварчилгааны стандартын дагуу савлаж боосон, тухайн ачааг усан замын тээврийн хэрэгслээр аюулгүй тээвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой.

3.1.12. Аюултай ачааны таних тэмдэг, тэмдэглэгээнд аюултай ачааны оноосон нэр, ангиллын зэрэг, тухайн ачаанд олгогдсон НҮБ-ын дугаар /өмнө нь UN үсэг тавигдана/, савлалтын багц зэргийг илгээгч болон хүлээн авагчийн нэр хаяг, аюултай ачааны техникийн нөхцөлд тусгагдсан бусад мэдээллийг тэмдэглэсэн байна.

3.1.12.1. Аюултай ачааны техникийн зааварчилгад тусгагдсан ерөнхий болон нэмэлт шаардлагууд, мөн энэхүү журамд заасан шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд тэдгээр шаардлагуудыг хангасан тухай баталгаажуулж бичгээр үйлдсэн байна.

3.1.12.2. Аюултай ачаа тээвэрлэгч, түүний багийн гишүүд, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид болон ханялтыг хэрэгжүүлж буй томилогдсон төлөөлөгчдөд тухайн тээвэрлэх гэж буй аюултай ачаатай холбоотой үүсэж болзошгүй аливаа осол, зөрчил, онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээний зааварчилгаа, аюултай ачааны техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагатай бусад мэдээллээр хангасан байна.

3.1.12.3. Аюултай ачаа тээвэрлэх замнал /маршрут/-ыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, тэдгээрээс эрх олгосон байгууллага, албан тушаалтан батлана.

3.1.13. Цацраг идэвхит болон халдвар үүсгэгч бодис, шингэн хор зэрэг аюулын өндөр зэрэгтэй бодис асгарсан тохиолдолд аливаа үйл ажиллагаа нэн даруй зогсоож, протокол үйлдэн холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээллэх үүрэг хүлээх бөгөөд, хэрэв химийн бодисын нөхцөл байдлыг үнэлэх боломжтой, бага эрсдэлтэй

хортой бодис эсхүл бага хэмжээний асгарсан тохиолдолд холбогдох сургалтад хамрагдсан, хөдөлмөр хамгааллын хувцастай, алдагдлыг бууруулах зориулалтын бүрдэл, хэрэгсэлтэй ажилтан цэвэрлэж болно.

3.1.14. Аюултай ачааны техникийн нөхцөлд тухайн аюултай ачааг энгийн бусад ачаатай хамт тээвэрлэхийг хориглосон заалт байвал хамт тээвэрлэхийг хатуу хориглоно.

3.1.15. Аюултай ачааг хүн, мал амьтан болон ахуйн хэрэгцээний, хүнсний бүтээгдэхүүнийг аюултай ачаатай хамт ямар ч тохиолдолд тээвэрлэхийг хатуу хориглоно.

3.1.16. Аюултай ачааны техникийн нөхцөлд заагаагүй бол бусад тохиолдолд аюултай ачааг багийн гишүүдийн гар тээш болон биед авч явахыг хориглоно.

3.2. Аюултай ачааг хүлээн авах, хүлээлгэж өгөх:

3.2.1. Аюултай ачааг хүлээн авах ба хүлээлгэж өгөх үйл ажиллагааг зохих зөвшөөрөл бүхий тээвэрлэгчийн эзэмшлийн талбай, агуулахад гүйцэтгэнэ.

3.2.2. Аюултай ачааг нийтийн зогсоол, талбайд шилжүүлэн ачихыг хориглоно.

3.2.3. Аюултай ачаа хүлээн авагч нь өөрийн хаягаар ирсэн аюултай ачааг хүлээн авахаас татгалзах эрхгүй.

3.2.4. Аюултай ачааг хүлээлгэж өгөх, хүлээн авахад орон нутгийн захиргаа эсхүл эрх бүхий байгуулага, албан тушаалтан нээхийг зөвшөөрөөгүй тохиолдолд дур мэдэн ачааг задлах, нээх, буулгах, сэлгэн ачихыг хатуу хориглоно.

3.2.5. Аюултай ачааг хүлээн авах, хүлээлгэж өгөхөд үүсэж болзошгүй аливаа аюул ослоос урьдчилан сэргийлэх үүднээс хяналтан дор аюулгүй байдлыг ханган гүйцэтгэнэ.

3.2.6. Аюултай ачааг хүлээж авах үед тэмдэглэл, дагалдах баримт бичигт тусгагдсанаас өөр, заасан жингээс зөрүүтэй тохиолдолд акт үйлдэж хүлээж авахаас татгалзана.

3.3. Аюултай ачааны хайрцаг, сав, баглаа, боодол:

3.3.1. Аюултай ачаа илгээгч нь аюултай ачааг тухайн барааны стандарт, техникийн нөхцөлд тохирсон сав, баглаа, боодолтой тээвэрлүүлнэ.

3.3.2. Аюултай ачааг тээвэрлэхээр савлаж буй этгээд нь аюултай ачааны техникийн нөхцлийн дагуу, аюултай ачаа тээвэрлэх зориулалтын дагуу бүлэглэж савласан байна.

3.3.3. Аюултай ачааны сав, баглаа, боодол нь бат бөх, бүрэн бүтэн, ачаа нь асгарч гоожихооргүй, ачааг тээвэрлэх явцад бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр сайтар битүүмжилсэн байна.

3.3.4. Савлагдаж бэлэн болсон аюултай ачаанд таних тэмдэг, тэмдэглэгээ болон шошго тавих этгээд нь аюултай ачааны техникийн нөхцлийн дагуу нааж бэлдсэн байх ба эрх бүхий албан тушаалтан /байцаагч/-р шалгуулан баталгаажуулсан байна.

3.3.5. Аюултай ачааны хайрцаг сав, баглаа, боодол болон гадуурх боодлын шошго нь тухайн аюултай ачааны нэр төрлийг тодорхой зааж тэмдэглэсэн байх ба анхааруулга, санамжийг англи, монгол дээр бичсэн байна.

3.3.6. Аюултай ачааны сав, баглааны гадаргуу дээр асгарсан, гоожсон шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тээвэрлэлтэд хүлээн авахгүй.

3.3.7. Шилэн савлагаатай аюултай ачааг бат бөх хайрцагт үл шатах, шингээх чанартай материалаар жийрэглэж, хөдөлгөөнийг хязгаарлан байрлуулж тээвэрлэнэ.

3.3.8. Аюултай ачааны сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, эсхүл үрэгдэж гэмтсэн тохиолдолд нэн яаралтай усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, тэдгээрээс эрх олгосон байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж тээвэрлэлтийг зогсооно.

3.3.9. Аюултай ачааны сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдал онц ноцтой, их хэмжээгээр алдагдсан, үрэгдэж гэмтсэн тохиолдолд нэн яаралтай усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, тэдгээрээс эрх олгосон байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж ослын бүсийг хамгаалалтанд авч тусгаарлана.

3.4. Аюултай ачааг ачиж буулгах болон шилжүүлэн ачих:

3.4.1. Аюултай ачааг илгээгч ба хүлээн авагчийн эзэмшлийн, зохих зөвшөөрлийн зогсоолд ачиж буулгана.

3.4.2. Аюултай ачааг ачих, буулгах болон шилжүүлэн ачихад аль болох гар ажиллагаанаас татгалзаж, ачиж буулгах зориулалтын машин механизм ашиглана.

3.4.3. Аюултай ачаа ачиж буулгах, болон шилжүүлэн ачих явцад тухайн аюултай ачааны ангиллаас хамааран шаардлагатай багаж хэрэгсэл, эд зүйлсийг бэлтгэн хангасан байна. Аюултай ачааг ачиж буулгах үйл ажиллагааг зөвхөн өдрийн цагаар зохион байгуулах ба болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, бэлэн байдалд ажиллана.

3.4.4. Аюултай ачааг усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх явцад эсхүл ачиж, буулгахад онгоцны тавцан болон ачиж буулгах техник, хэрэгсэлд эвдрэл, гэмтэл үүссэн бол тухайн эвдрэл, гэмтлийн шалгааныг тогтоож, засварлах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч ажиллана.

3.4.5. Аюултай ачааг ачиж буулгах болон шилжүүлэн ачих зогсоол нь орон нууц, нийтийн барилга, байгууламж, бусад аюултай ачаа хадгалах, ачиж буулгах, шилжүүлэн ачигддаг зогсоолоос 100-200метр хол зайтай байна.

3.4.6. Аюултай ачааг ачиж буулгах, шилжүүлэн ачихад урьдчилан зогсоолыг бэлдэж аюулгүй ажиллагааг хангасан байна.

3.4.7. Аюултай ачааг байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлсээс хамааран хүлээн авах боломжгүй тохиолдолд зориулалтын зогсоолд байршуулан эрх олгосон байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

**ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ
ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН**

- 4.1. Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрлийг “Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх журам”, “Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам” болон бусад тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагыг хангаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоно.
- 4.2. Нэг удаагийн аюултай ачаа тээвэрлэлт хийх зөвшөөрлийг усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд аймаг, хот, сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын усан замын тээврийн асуудал хариуцсан албан тушаалтан, тухайн орон нутаг дахь мэргэжлийн хяналтын алба эсхүл эдгээр байгууллагаас эрх олгосон тээвэр /усан зам/-ийн хяналтын улсын байцаагч олгож, аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой баримт бичиг, мэдээллийг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 21 хоно дотор хүргүүлнэ.
- 4.3. Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой гарын авлага, аргачлал, арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол хангаж, тээвэрлэлттэй холбоотой үүдэн гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 1-ээс доошгүй удаа сургалт зохион байгуулна.
- 4.4. Тусгай зөвшөөрөлгүй эсхүл тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлүүлэхгүй байх хяналтыг Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон тус байгууллагаас эрх олгосон тээвэр /усан зам/-ийн хяналтын улсын байцаагч нар хавсран хэрэгжүүлнэ.
- 4.5. Аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой аливаа зөрчил гарсан тохиолдолд Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, тус байгууллагаас эрх олгосон тээвэр /усан зам/-ийн хяналтын улсын байцаагч нар Онцгой байдлын ерөнхий газар болон хууль хяналтын байгууллагатай нэн даруй холбоо тотоож болзошгүй аюул, ослыг таслан зогсоох арга хэмжээ авч хамтран ажиллана.
- 4.6. Аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой аливаа маргааныг Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон холбогдох дээд байгууллагаар хянан шийдвэрлүүлнэ.
- 4.7. Энэхүү журмын шаардлагыг зөрчсөн, аливаа зөрчил, дутагдал гаргасан нь тогтоогдсон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд Монгол Улсын Усан замын тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

